

ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХАРААН ДООРХИ МОНГОЛ УЛС

Б.Хөгжилт¹

Хураангуй: Зүүн Хойд Ази гэдэг нь анхандаа бүс нутгийн хамтын ажиллагааны ойлголт байсан ч хожим нь геополитикийн ойлголт болсон байна. Зүүн Хойд Ази нь “эх газрын эрх” болон “далайн эрх”-ийн уулзварт орших бөгөөд олон улсын стратеги зүйд хүлээн зөвшөөрөгдсөн “олон улсын стратегийн суурь шугамын” зүүн үзүүр болж, их гүрнүүдий өрсөлдөөний талбар, дэлхий дахины анхаарлын төв байсаар иржээ. Зүүн Хойд Азийн нөхцөл байдал нь дөрвөн их гүрний хүчин чадал болон тэдгээрийн харилцаанаас голлон хамаарна. Тус бүс нутагт орших эмзэг бүсүүд бол гео-стратегчийн гар дүрэх орон зай юм. Хэдийгээр Монгол Улс нь жижиг улс боловч түүний геополитик, гео-эдийн засгийн байр суурь нь ер бусын агаад бүс нутгийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж болох юм. Үүнд: Монгол Улс нь 1-рт, Хятад-Оросын хоорондох, цаашилбал Зүүн Хойд Азийн жийргэвч бүс. 2-рт, Их гүрнүүдийн “урагилах” зангилаа цэг. 3-рт, Бүс нутгийн болон дэлхий дахины шинээр хөгжиж буй эрдэс баялаг эрчим хүчий том нийлүүлэгч бөгөөд үүгээрээ дамжуулан бүс нутгийн интеграцийн чухал түлхэх хүчин. 4-рт, Евразийн эх газрын дөт зам шугам. 5-рт, Нүүдлийн соёл иргэншлийн өлгий бөгөөд соёл иргэншилүүдийн уулзвар нутаг байж бүс нутаг хийгээд дэлхий дахины соёл иргэншлийн харилцан суралцахад чухал ач холбогдолтой байна.

Түлхүүр үгс: Зүүн Хойд Ази, бүс нутаг, Монгол Улс, байр суурь

Abstract: Northeast Asia is a concept arising from regional cooperation and has now become a political term. Northeast Asia is at the “sea power” and “ground power” at the interchange. Northeast Asia is in the “international strategic baseline” on the east side, is a national dispute. Although Mongolia is a small country, but in the geo-political and economic status of extraordinary, can play an important role in regional

1 ӨМИС-ийн “Монгол Улсыг судлах төв”-ийн дэд профессор. E-mail: hugjilt_@126.com

Зүүн хойд азийн хараан доорхи Монгол улс

affairs 1.Mongolia is the buffer zone of other countries 2.Mongolia is an important springboard for countries out of the region 3.Mongolia is an important new mineral area in the world 4.Mongolia is a convenient channel for the Eurasian Continental Bridge 5.Mongolia is the birthplace of nomadic civilization and continues,But also the intersection of major civilizations, the exchange of civilization is of great significance.

keyword: *Northeast Asia, area, Mongolia, status*

Зүүн Хойд Ази гэдэг нь Зүүн Ази ба Хойд Азийн нийлбэр ойлголт бөгөөд энэхүү ойлголтын гол зорилт нь бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс Хойд Азид орших асар их нөөц баялагтай Оросын Сибирь, Алс Дорнодыг тус бүс нутагт хамааруулсанд оршино. Зүүн Хойд Азийг явцуу болон дэлгэрэнгүй гэсэн хоёр утгаар ойлгож болно. Явцуу утгад Монгол Улс, Хойд Солонгос, Өмнөд Солонгос, Япон, Хятадын зүүн хойд ба хойд бүс, Оросын Алс Дорнод ба Сибирийн бүсийг хамааруулах бол дэлгэрэнгүй утгаар нь дээрх зургаан улсыг бүхэлд нь хамааруулна. Зүүн Хойд Азийн зүүн бүс нь хүн ам олонтой бөгөөд Япон, Өмнөд Солонгос, Хятадын зүүн хойд ба хойд бүсийн боловсруулах үйлдвэрлэл бүхий дээд технологийн хөгжингүй салбартай. Энд дэлхийн 100 топ аж ахуйн талаас илүү нь байрлах ба үүгээрээ дэлхийн эдийн засгийн төв дорно зүгт шилжиж буйг илтгэдэг. Зүүн Хойд Азийн баруун ба хойд бүс нь хүн ам цөөн, хээр тал, говь цөл, ой хөвч бүхий эх газрын гүнд орших өргөн уудам нутагтай ба эрдэс баялаг, эрчим хүчний асар их баялагтай дэлхийн зэрэглэлийн нөөц бүс болно.

Зүүн Хойд Ази нь “эх газрын эрх” болон “далайн эрх”-ийн уулзвар ба олон улсын стратеги зүйд хүлээн зөвшөөрөгдсөн “олон улсын стратегийн суурь шугамын” зүүн үзүүрт оршиж, их гүрнүүдийн өрсөлдөөний талбар болж дэлхий дахины анхааралын төв байсаар иржээ. Эдүгээ ч үндэстэн хоорондын хардлага, нийгмийн тогтолцооны ялгаа, үзэл ухамсарын сөргөлдөөн, их гүрнүүдийн ашиг сонирхолын зөрчил зэрэг “хүйтэн дайн”-ы улбаа лавширч, шинэ хуучин асуудал ягшран зууралдсан ямар нэгэн хэмжээ хориогүй сөргөлдөөн нь халуун мөргөлдөөн болон хувирах магадлал өндөртэй болохоор бүс нутаг ба дэлхий дахины энх тайван, хөгжилд аюул заналхийлэл учруулж мэдэх бүс нутаг хэвээр байна.

Зүүн Хойд Азийн нөхцөл байдал нь дөрвөн их гүрэн болох Америк, Хятад, Орос, Японы хүчин чадал болон тэдгээрийн харилцаанаас голчлон хамаарна. Америк бол энэ цагийн цор ганц супер хүчирхэг гүрэн бөгөөд Америк - Япон, Америк – Япон - Өмнөд Солонгосын холбооны “Азийн жижиг НАТО”-д тулгуурлан Зүүн Хойд Ази дахь өөрийн улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын ашиг сонирхол хийгээд Япон, Өмнөд Солонгосын улс төрийн аюулгүй байдлыг хангахын хамт, Зүүн хойд Ази дахь өрсөлдөгч этгээдүүдийн стратегийн сорилтыг хазаарлахыг эрмэлзэж байдаг. АНУ нь Зүүн Хойд Азид цэргийн тэнцвэржүүлэгчийн дүрд тоглож, нэг талаар Японыг холбооны системд татан оруулж өөрийн ашиг сонирхолд үйлчлүүлэх, нөгөө талаар Японы хүчийг хяналтын хэмжээнд барьж, Японыг ашиглан Хятад, Оросыг хязгаалахын зэрэгцээ мөн энэхүү нэрийн доор Япон дахь цэргийнхээ оршин тогтнохуйг хангадаг байна. АНУ нь Хятад, Оросын харилцаанд идэвхитэй бодлого хэрэгжүүлж байдаг. Үүний гол санаа нь хүчний бус аргаар хүчирхэгжиж байгаа улсын тэлэлтийн хүчин зүйлийг сааруулж, Хятад, Оросыг олон улсын нийгэмлэгт нэгтгэхийн зэрэгцээ, АНУ-ын нөлөөг тус хоёр улсын дотоод хэрэгт нэвчүүлж, эдүгээгийн Зүүн Хойд Азийн улс төр, аюулгүй байдлыг хангах явдалд оршино.

Хятад бол хүчирхэгжиж буй том гүрэн бөгөөд түүний хөгжил дэвшил нь ойрх ирээдүйд Зүүн Хойд Азийг дэлхийн төв болгох боломжтой. Тухайн цагт Зүүн Хойд Ази нь их гүрнүүдийн анхаарлыг улам ч ихээр татах ба тус бүс нутгийн нөхцөл байдал нэн төвөгтэй болно. Хятадын дэвшүүлсэн аюулгүй байдлын шинэ үзэл, “Бүс ба Зам” санаачлага, хүн төрөлхтөний хувь заяаны хамтын нийгэмлэгийн ойлголт нь олон улсын хамтын нийгэмлэгт аажмаар хүлээн зөвшөөрөгдөж байна. Хятад нь “Бүс ба Зам” санаачлагынхаа зам дагуух улс орнуудтай хамтдаа зөвшилцөх, хамтдаа байгуулах, хамтдаа хуваалцах зарчмын дагуу уялдан хөгжүүлж байгаа нь бүс нутгийн хүчний тэнцвэр алдагдахаас шалтгаалсан мөргөлдөөнийг эрс намтгаах чиг хандлагатай болох нь харагдаж байна. Нөгөө талаар, Хятадын “гар дүрэхийн эсрэг” бодлого эрчимжсэнээс АНУ нь Б.Обамагийн үеэс эхлэн ирээдүйд бүс нутгийн үйл хэрэгт тусгаарлагдахгүйн үүднээс Ази, Номхон далайд дахин буцах стратеги хэрэгжүүлсэн байна.

Орос бол дахин сэргэн мандаж буй том гүрэн юм. Зөвлөлт задарснаас хойш Орос нь “зовлон зүдгүүр”-ийн цаг үеийг даван гарч 21-р зуунаас хойшхи арваад жилийн хөгжлийн үр дүнд дэлхийн төв тайзанд нэгэнт буцан иржээ. ОХУ нь Өрнө дахины аюул заналхийллыг аргацаах, ирээдүйд дорно, өрнийн цохилтыг зэрэг амсахаас болгоомжлон Хятадтай хамтрахыг чухалчлан сонголоо. Энэ байдал нь Зүүн Хойд Азийн харьцангуй тогтвортой байдалд ер бусын ач холбогдолтой юм.

Хэдийгээр Хятад - Оросын харилцаа нь Америк - Японы харилцаанаас гаднах нэлээд тогтвортой харилцаа болон хөгжиж, хоёр улсын хоорондох эдийн засгийн харилцан нөхөх байдал нь түүхэн аль ч үеэсээ давсан ч хоорондоо ямар нэг бодитой эвсэл байгүйлаагүй юм.

Шинзо Абэ эрх барьснаас хойш Японы улс төрийн баруун жигүүрийн хүчин газар авч, Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах, бүс нутгийн үйл хэрэгт оролцох, “хэвийн улс” болох оролдлогийг хүчтэй явуулах болсон нь энэ бүс нутгийн улс орнуудын хувьд “Японы милитаризм” дахин амилах айдасыг төрүүлж байна. Хэрэв энэ байдал цааш үргэлжилбэл гарцаагүй Хятад, Орос тэр ч байтугай АНУ-ын шахалтад өртөх болно. Энэ нь АНУ - Японы эвсэл тийм ч бат бэх бус гэдгийг илтгэн харуулахын зэрэгцээ хоёр талын эдийн засгийн өрсөлдөөн ба АНУ-ын цэргийг нутгаасаа гаргах японы ард олны эсэргүүцэл нь хоёр талын харилцаанд ан цав үүсгээд байна. Гэсэн ч хоёр орны стратегийн ашиг сонирхолыг харгалзан хоёр талаас эдийн засгийн өрсөлдөөн ба аюулгүй байдлын хамтын ажиллагаандаа зохицуулалт хийснээр АНУ - Японы харилцаа нь зохицуулалтын тэнцвэрт байдалд орших болжээ. Хүмүүсийн анхаарлыг эрхгүй татах нэгэн зүйл бол Япон улс өнөөг хүртэл цөмийн зэвсгийг хязгаарлах олон улсын аливаа гэрээнд гарын үсэг зурахаас татгалзсаар байгаа явдал болно. Хэрэв Япон нь “хэвийн улс” болбол түүний технологи, санхүүгийн хүчин чадал, цөмийн эрчим хүчинд ашиглаж буй ураны нөөц зэрэг нь цөмийн зэвсэг хийхэд ямар ч саадгүйгээр үл барам дэлхий дахинд цөмийн зэвсгийн шинэ өрсөлдөөн бий болгож мэдэх юм.

Энэ бүс нутагт эмзэг цэг олон байдаг. Тухайлбал Хойд Солонгосын цөмийн зэвсгийн болон Тайваны асуудал, арал олтриг далай тэнгис

дэх эрхийн болон хилийн маргаан зэрэг нь стратегийн тоглогчдын сонирхолын цэг болж болох бөгөөд бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдалд олон зүйлийн тодорхой бус асуудлыг үүсгэж мэдэх юм.

Шилжилтийн дараах Монгол Улс нь хөрш хоёр оронтой харилцах харилцааг гадаад харилцааны тэргүүлэх чиглэлд тавьсан билээ. Харин Зүүн Хойд Ази болон Ази-Номхон далайн улс орнуудтай голчлон түншлэх, “гуравдагч хөрш”-ийн бодлогоор дамжуулан хоёр хөрш лүгээ харилцааг тэнцвэржүүлэх, өөрийн ашиг сонирхолыг нэмэгдүүлэн тэнцвэртэй, эвсэлд үл нэгдэх, төвийг сахисан цөмийн зэвсэггүй статус бүхий гадаад бодлого хэрэгжүүлснээр Монгол Улсын олон улс дах байр суурь дээшилсэн байна. Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн хэмжээ өсөн нэмэгдэх болон “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор” байгуулах төсөл хэрэгжихийн хэрээр тус улсын урьдын эдийн засгийн тусгаарлагдмал байдалд нь өөрчлөлт гарч, улмаар ашигт малтмалын эрэлт ихтэй их гүрнүүдийн анхаарлын төвд орж байна. Монгол Улс нь эх газрын нөөц баялаг ихтэй орны хувьд түүний хөгжил нь даяаршил болон бүс нутгийн интеграцид нэгдэх бодлого, арга зам, хэм хэмжээнээс ихээхэн хамааралтай юм. Энэ цаг үед хэрэгжиж буй гурван улсын эдийн засгийн коридороос гадна харьцангуй эртнээс яригдаж эхэлсэн Зүүн Хойд Азийн хамтын ажиллагааны механизм нь тус улсын хөгжлийн бас нэгэн гарц үүд мөн бөгөөд чингэхдээ энэ нь бүс нутгийн тогтвортой байдал ба харилцан итгэлцлээс ихээхэн хамааралтай болно. Гэвч эдийн засгийн даяаршил нь бас сөрөг талтай байдаг нь мэдээжийн хэрэг билээ. Ялангуяа бага жижиг улс орны хувьд нийгэм, соёлын цохилт болон баян, ядуугийн ялгаа нэмэгдэхээс урьдчилан сэргийлэхгүй байхын аргагүй юм. Мөн Монгол Улсын эдийн засаг нь уул уурхайгаас хэт хамаарал бүхий бүтэцтэй ба засаглалын боловсронгуй бус тогтолцоо нь тус улсын хөгжлийн дотоод саад тотгор болж байна.

Хэдийгээр Монгол Улс нь энэ бүс нутгийн нэгэн жижиг улс боловч түүний геополитик, гео-эдийн засгийн онцлог нь тун өвөрмөц, ер бусын ач холбогдолтой юм. Субъектив, объектив нөхцөл байдлаас авч үзэхэд Монгол Улс нь Зүүн Хойд Азид дараах байр суурьтай байна.

Нэг. Монгол Улс нь Хятад-Орос, Зүүн Хойт Азийн жийргэвч бүс болох нь

Монгол Улсын жийргэвч байдал нь газар зүйн болон улс төрийн давхар ач холбогдолтой. Газар зүйн ойлголтын хувьд энэхүү жийргэвч бүс нь Хятад, Оростой шууд хамааралтай бөгөөд 1000-2000 км-ийн хэвтээ босоо чиглэлд Хятад болон Оросын чухал бүс нутгийг тусгаарлаж байдаг. Хүчний тэнцвэр алдагдах буюу дайсагнах үед хилийн асар урт шугам нь чухал бүсүүдийн шууд хяналт цохилтийн хүрээнд орших хардлага, үл итгэлцэлээс зайласхийх хүчин зүйл болж, хүч хэрэглэх стратегийн эдийн засгийн өртөгийг нэмэгдүүлж, газар зүйн тусгаарлах буфер үүрэг гүйцэтгэх болно. Тоон системийн тагналт ба дунд, алсын зайн цохилтын чадвар нэмэгдсэн энэ цагт хэдийгээр газар зүйн саадын нөлөө суларсан ч түүний хоёр том гүрний хооронд орших цэрэг, улс төрийн буфер үүрэг нь харин улам нэмэгдсэн байна. Улс төрийн хувьд Монгол нь зөвхөн хоёр хөршид төдийгүй бүхий л бүс нутгийн буфер бүс болдог. Эвсэлд үл нэгдэх, гадаадын цэргийн баазыг нутаг дэвсгэртээ үл байрлуулах, цөмийн зэвсэггүй статус, үндэсний язгуур эрх ашиг хөндөгдөөгүй цагт хоёр хөршийн харилцаанд төвийг сахих, өөрийн нутаг дэвсгэрт аль нэгэн хөршийн эсрэг үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг Монгол Улсын эдүгээ хэрэгжүүлж буй гадаад бодлого нь хоёр хөрш улс болон бүс нутгийн хувьд үлгэр жишээ буфер үүргийг гүйцэтгэж байна. Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус нь НҮБ-ын Ерөнхий Ассемблей болон Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн улсуудаар бүрнээ баталгаажуулсан статус болж, бүс нутгийн болон даян дэлхийн цөмийн зэвсгээс ангид байдал, аюулгүй ба тогтвортой байдалд оруулж буй жинтэй том хувь нэмэр болно. Монгол Улс энэ бүс нутгийн улс болгонтой ямар нэгэн зарчмын маргаангүйгээр үл барам харин ч нөхөрсөг сайн харилцаатай байгаа нь бүс нутгийн хэрэг явдлыг яриа хэлцэл, энх тайвны замаар шийдэж байх аюулгүй байдлын шинэ механизм буй болгох шинэ тавцан болж болно. Ялангуяа түүний санаачилсан Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын талаарх “Улаанбаатар яриа хэлцэл” нь бүс нутгийн олон талт аюулгүй байдлын механизм бүрэлдэн тогтоох үйл хэрэгт тодорхой үр дүнд хүрч болохуйц нэгэн сайн хувилбар болжээ.

Хоёр. Монгол Улс нь бүс нутгийн болон бусад их гүрнүүдийн “урагшлах” чухал зангилаа цэг болох нь

Энд дурдагдан буй зангилаа цэг гэдэг нь хоёр хөршид нөлөөлөх буюу бүс нутагт үлгэр жишээ үүрэг гүйцэтгэж чадахуйц тулах цэгийг хэлнэ. “Монгол бол Баавгайн өвөр, Лууны нуруунд шаасан шаантаг”, “Монгол бол Азийн ардчлалын үлгэр жишээ” гэх зэргээр Америкийн зарим улс төрчид болон эрдэмтдийн хэлсэн үг нь энэ мэт утгатай ажээ. Олон улсын харилцааны практик ч үүнийг гэрчлэх бөгөөд АНУ, Япон зэрэг их гүрэн энэ мэт санаархал цухалзуулсаар байна. Гэхдээ Монгол Улсын хэрэгжүүлж буй гадаад бодлого, Хятад, Монгол, Орос гурван орны харилцаа, ялангуяа “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор” байгуулах төсөл хэрэгжүүлж байгаа эдүгээгийн нөхцөл байдлаас харахад, гурван орны эдийн засгийн харилцан түшилцэх хэмжээ хийгээд улс төр, аюулгүй байдлын нийтлэг ашиг сонирхол улам бүр нэмэгдэж байна. Харин цэргийн бааз байгуулах ямар ч боломжгүйгээс гадна, улс төр, соёл, үнэт зүйлс, нийгмийн тогтолцоо дахь зангилаа цэгийн боломж ч сааран суларч байна. Монгол Улс цэрэг дайны зангилаа цэгийн үүрэг гүйцэтгэхэд хүрвэл тэр нь зайлшгүй утгвар нөхцөлийг шаардах учиртай. Энэхүү утгвар нөхцөл гэдэг нь түүний оршин тогтнох гадаад нөхцөл ноцтой эвдэгдсэний улмаас өөрийн тусгаар тогтнолын баталгаагаа хангахын аргагүйд хүрвэл аль нэгэн хүчирхэг гүрнийг түшин дагахыг лавтай хэлэх юм.

Зангилаа цэгийн боломж бүхий Монгол Улсын хувьд их гүрнүүдийн гео-стратегийн тоглоом нь нэг талаар сорилт болох ба нөгөө талаар боломжийг буй болгож байдаг. Монгол Улсын хэрэгжүүлж байгаа “гуравдагч хөрш”-ийн бодлого нь хоёр хөршийн нөлөөг сааруулан тэнцвэржүүлэхийн хамт, үндэсний ашиг сонирхолоо нэмэгдүүлэх зорилттой байж, эвсэлд үл нэгдэх, төвийг сахихын урьдал нь хоёр хөршийн язгуур ашиг сонирхолыг хохироох асуудлыг агуулахгүй юм. Хэрэв түүний хоёр хөрш лүгээгийн тэргүүлэх гадаад харилцааны чиглэл хувирдаггүй л юм бол энэхүү хэмжээн дэх үндэсний ашиг сонирхолоо нэмэгдүүлэх бодлого нь бие даасан тусгаар улсын хөгжлийн стратегийн бүрэлдэхүүн хэсэг болох нь ойлгомжтой. Гэхдээ “гуравдагч хөрш”-ийн бодлогод эмзэг нэгэн “хэмжээ”-ний асуудал бий. Хэрэв хэрэгжилт нь “хэмжээ”-нээс хэтэрвэл геополитикийн

өрсөлдөөний золиос болохын хамт, бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж мэдэх эрсдэлтэй.

Гурав. Монгол Улс нь бүс нутгийн төдийгүй дэлхийн шинээр хөгжиж буй эрдэс баялаг, эрчим хүчний том нийлүүлэгч орон бөгөөд бүс нутгийн интеграцийн чухал түлхэх хүч болох нь

Монгол Улсын ашигт малтмалын төрөл зүйл, нөөц агууламж, олборлох нөхцөл, зах зээлийн зай, тусгай зөвшөөрлийн төлбөр зэрэг нь цөм өөрийн гэсэн давуу талтай. Сүүлийн жилүүдэд зах зээлийн үнэ ханшны хэлбэлзэл хийгээд бодлогын тогтворгүй байдлаас улбаалан тус улсын уул уурхайн салбарын хөгжлийн хурд саарсан ч Монгол Улсыг дэлхий нийтээрээ Австрали, Бразил, Энэтхэг, Орос, Персийн булангийн орнууд зэрэг уламжлалт эрдэс баялагийн том улсаас гаднах шинээр хөгжиж буй нөөц баялаг, эрчим хүчний нийлүүлэлтийн том улс хэмээн хүлээн зөвшөөрж байна.

Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлснээр² Монгол Улс ашигт малтмалын нөөцөөрөө дэлхийд 7-р байр эзлэж байгаа бөгөөд 2015 оны эцсийн байдлаар зэсийн хүдрийн металл нөөц 45.8 сая тонн ба Азид тэргүүлэх Эрдэнэтийн зэс-молибдений орд, Цагаансуврагын зэс-молибдений орд, Оюутолгойн зэс-алтны ордууд тус улсын стратегийн ордын жагсаалтад хамрагджээ. Монгол Улсын нүүрсний нөөц 25.8 тэрбум тонн бөгөөд энэ нь дэлхийд 10-р байрыг эзлэж байна. Зөвхөн Тавантолгойн ордын нөөц нь JORC стандартын дагуу 6.5 тэрбум тонн байгаагаас коксжих нүүрсний нөөц ойролцоогоор 2 тэрбум тонн байна.³ Үүнээс гадна Багануур, Нарийнсухайт, Шивээ-Овоогийн ордууд нь стратегийн ордод хамрагдав. Монголын төмрийн хүдрийн металл нөөц 390 сая тонн ба Төмөртэйн орд нь стратегийн ордын жагсаалтад хамрагджээ. Алтны металл нөөц нь 598,000 кг бөгөөд энэ нь дэлхийд 10-р байр эзлэж байна. Гацууртын алтны орд стратегийн ордын жагсаалтад оров. Молибдений металл нөөц 660,000 тонн бол цайрын металл нөөц 1.11 сая тонн ажээ. Төмөртийн-Овооны орд нь стратегийн ордны жагсаалтад оров. Хайлуур жоншны металл нөөц 15.78 сая тонн, үйлдвэрлэл, экспортын хэмжээгээр тус бүр дэлхийд


² Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар. 2015 оны 12 дугаар сарын эмхтгэл, http://mram.gov.mn/?page_id=128.

³ Тавантолгой ТӨХК. <http://tavantolgoi.mn.2015.03.22>.

гурав, хоёр дугаарт байрлаж байна. Ураны металл нөөц 125,000 тонн бөгөөд энэ нь дэлхийд 10-рт байрлах үзүүлэлт юм. Мардай, Дорнот, Гурванбулаг зэрэг ордууд нь стратегийн ордын жагсаалтад багтсан байна. Газрын ховор элементийн металл нөөц 1.83 сая тонн бөгөөд энэ үзүүлэлт нь дэлхийд дээгүүр байр эзэлнэ. Харин фосфоритын батлагдсан нөөц 6 тэрбум тонн бөгөөд энэ нь Азид 1-рт, дэлхийд 5-рт байрлах үзүүлэлт юм. Фосфорит нь тус улсын Хөвсгөл нуурын хотгорт тархах⁴ ба Бүрэнхааны фосфоритын орд нь стратегийн ордын жагсаалтад хамрагдсан байна.

Монгол Улсын ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь 80-90 байж, экспортын хэмжээ нь хэлбэлзэлийн дунд өсөн нэмэгдэж байна (доорх хүснэгтийг үзнэ үү).

Хүснэгт: Монгол Улсын ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт, импорт



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, www.1212.mn.2016.12.03.

Үүнээс гадна, Монгол Улс нь сэргээгдэх эрчим хүчний нөөцөөрөө дэлхийд дээгүүр байр эзэлнэ. Ашигт малтмал, эрчим хүчний хэрэгцээт

⁴ Монгол Улсын уул уурхайн баялаг: <http://www.mn.wikipedia.org/wiki/2015.02.20>.

зах зээлийн тархалтаас үзвэл Хятад нь ирээдүйд тогтвортой хугацаанд дэлхийн хамгийн том хэрэглэгч улс хэвээр, харин Япон, Өмнөд Солонгос мөн чухал хэрэглэгч улс байх төлөвтэй байна. Эрэлт, нийлүүлэлтийн газар зүйн дөхөм байршил нь хоёр талт болон бүс нутгийн хамтын ажиллагаанд томоохон түлхэц болж байгаа бөгөөд бүс нутгийн улс орнууд ч энэ талаар бүс нутгийн хамтын ажиллагааны хэтийн төлвийн олон төсөл хөтөлбөр дэвшүүлүүд байна.

Дөрөв. Монгол Улс нь Евразийн эх газрын дөт зам шугам болох нь

Эх газрын зам тээврийн технологийн ахиц дэвшил хийгээд дэлхийн геополитик, гео-эдийн засгийн нөхцөл байдалд гарсан шинэ өөрчлөлт нь Монгол Улсын Хятад-Орос, Ази-Европын хооронд орших газар зүйн давуу талыг товойлгож байна. Монгол Улсын санаачилсан “Хөгжлийн зам” төсөл нь Хятад-Оросын хооронд орших газар зүйн давуу талаа ашиглаж, төмөр зам, хурдны зам, газрын тос ба байгалийн хийн дамжуулах хоолой, өндөр хүчдэлийн эрчим хүчний шугамаар Хятад, Оросыг холбох зорилготой. “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр” батлагдсан нь Монгол Улсын зам харилцааны бүтээн байгуулалтын агуулагыг асар ихээр баяжуулсан байна.

Монголын төмөр замаар жишээ болгон өгүүлье. Эдүгээ тус улс Оростой хоёр, Хятадтай нэг шугамаар төмөр замаар холбогдож буй бөгөөд байгуулж байгаа буюу төлөвлөж буй нь Оростой нэг шугамаар, Хятадтай гурван шугамаар нэмж холбогдох болно. Монгол Улс нэгэнт НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комиссын хэрэгжүүлж байгаа Азийн авто замын сүлжээ, дамжин өнгөрөх төмөр замын сүлжээний төсөлд нэгдэн орж, Монгол Улсын нутаг дэвсгэр дэх Азийн АНЗ, АН32, АН4 хурдны автозамын сүлжээний бүтээн байгуулалтын талаар идэвхтэй ажиллаж байна. “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудлын төсөл”-ийг нэгэнт эхлүүлж, 2018 онд ашиглалтад оруулах төлөвтэй байна. Тус онгоцны буудал ашиглалтад орсноор Монгол нь Евразийн дамжин өнгөрөх тээврийн зангилаа болж болох юм.⁵

Евразийн эх газрын болон далайн хослуулсан тээврийн талаар өгүүлэхэд одоохондоо Тяньжин боомт нь Монгол Улсын хамгийн дөт

5 Зөвхөн нэг л төмөр замын боомтоор Хятад зүг зөөвөрлөдөг Монгол “Талын замаа” яаравчлан нэвтрүүлэхийг хүсч байна. “Лавлах сонин” http://www.guancha.cn/Neighbors/2015_07_10

далайн гарц байна. БНХАУ-ын дөрвөн Транс тээврийн нэг болох Тяньжин-Монголын Евразийн хамтарсан тээврийн зам (бас Тяньжин төсөл гэдэг) нь Тяньжиний Шиньган-аас Бээжин, Датун, Эрээнийг дамжин Монголд орж Улаанбаатар, Алтанбулагаас умарш ОХУ-ын Транс-Сибирийн төмөр замаар Брест, улмаар баруунш Роттердам боомтод хүрдэг юм. Тус чиглэлийн тээвэр нь Кейп чиглэлийнхээс 1/2 гаруй дөт бөгөөд Суэцийнхээс 1/3 зай, 35 хоногийн хугацаа, 20-25% тээврийн зардал хэмнэх юм байна.⁶

Одоогын байдлаар Тяньжин-Монголын хамтын ажиллагаанд шинэ ахиц гарч, Монгол Улс нь Тяньжиний Биньхай шинэ дүүргийн Дүнжян гаалийн баталгаат бүсийн 10 га газарт 50 жилийн хугацаатай “Жиньмэн тээвэр логистикийн төсөл” хэрэгжүүлэх гэрээнд Тяньжинтай гарын үсэг зурсан байна.⁷

2014 оны 10 дугаар сарын 24-нд Монгол Улсын УИХ-аар баталсан төмөр замын тогтоолд Таван толгой-Гашуунсухайт, Хөөт-Бичигт чиглэлд нарийн царгийн төмөр зам тавихаар болов. Үүнд Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын газар шорооны ажил нэгэнт дуусах шатандаа оржээ. Хөөт-Бичигт чиглэлийн эрдэс баялгийн тээвэрлэлтийн төмөр зам нь, Жиньжоү боомтыг ашиглах асуудал нэгэнт шийдэгдсэн байна. Төлөвлөгдөж буй Чойбалсан (эсвэл Хөөт) - Жиньжоү төмөр замын нийт урт нь 1200 гаруй км. Үүний Чойбалсан (эсвэл Хөөт)-Бичигтын замын урт 420 км, БНХАУ-ын нутаг дахь замын урт 850 км бөгөөд хоёр шугмын сонголттой юм. Тус төмөр зам нь Чойбалсан-Эрэнцавын төмөр замаар ОХУ-ын Транс-Сибирийн төмөр замтай залгалдана. Тус шугам нь Манжуураар дамжин Далянь боомт хүрэхээс 900 гаруй км-ээр, Улаанбаатар, Эрээн хотыг дамжин Тяньжинь боомт хүрэхээс 800 гаруй км-ээр дөт учир чухал ач холбогдолтой болно.⁸ “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор” байгуулах ахиц, бүс нутгийн интерактив хөгжил нь энэхүү хэтийн төлөв биелэхэд асар их түлхэц болж байна.

Тав. Монгол Улс нь нүүдлийн соёл иргэншлийн голомт ба соёл иргэншлүүдийн уулзвар бөгөөд бүс нутаг, дэлхий дахины соёл иргэншлийн харилцан суралцах үйлсэд ач холбогдолтой болох нь

6 Олон улсын мултимодаль тээвэр, эх газрын тээвэр _ Baidu номын сан, <http://wenku.baidu.com/>

7 Монголын төмөр зам, <http://www.mtz.mn>

8 Б.Хөгжилт: БНХАУ, Монгол Улсыг төмөр замаар холбох бодлого, үйл явцад хийсэн дүн шинжилгээ, “Олон улс судлал” 2014.№3

Соёлын агуулга нь цар хүрээний хувьд маш өргөн агаад үндэстэн бүр өөрийн бүтээсэн соёлын давуу талтай билээ. Монгол бол Күнзийн сургаалын соёл иргэншил, Үнэн алдартны соёл иргэншил, Исламын соёл иргэншлийн бүс нутагтай хөршилж, түүхэндээ хэдэн хэдэн том соёл иргэншлийн солилцоонд ба хүн төрөлхтний хөгжил дэвшилд үлэмж их үүрэг гүйцэтгэсэн Нүүдлийн соёл иргэншлийн өлгий бас хадгалан үлдсэн орон юм. Монголын өндөрлөгийн байгаль нийгмийн шалгарлаар нүүдлийн соёл иргэншил буй болж, байгалаа шүтэн хайрлах, зохистой ашиглах нүүдлийн үйлдвэрлэл, амьдралын горимд түшиглэж, мянга мянган жилийг дамжин байгалийн онгон дагшин байдлыг хадгалан үлдээж чадсан билээ. Энэ бүхэн нь өнөөдрийн экологийн соёл иргэншил, тогтвортой ногоон хөгжилд үнэ цэнэтэй ойлголт, туршлага болжээ. Аж үйлдвэрийн соёл иргэншил нь урьд өмнө байгаагүйгээр баялгийг бүтээхийн хамт, амьдрах орчныг ихээр муутгасан байна. Бид соёлын олон янз байдал, соёл иргэншлийн харилцан суралцахыг эрхэмлэж чадваас хүн төрөлхтний эв нэгдэлтэй, тогтвортой ногоон хөгжлийн нийтлэг зорилтод хүрэх болно. Объектив үүднээс хандвал Монгол нь бүс нутгийн хөдөө аж ахуй ялангуяа мал аж ахуйн шинэ загвар бүхий эрчимжсэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэгч улс болох бүрэн боломжтой байна.

Ашигласан материал

Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар. 2015 оны 12 дугаар сарын эмхтгэл, http://mram.gov.mn/?page_id=128.

Brzezinski, [The Grand Chessboard: American Primacy and its Geo-strategic Imperatives], Шанхайн ардын хэвлэлийн хороо, 1998 он.

Монгол Улсын уул уурхайн баялаг. <http://www.mn.wikipedia.org/wiki/2015.02.20>.

Зөвхөн нэг л төмөр замын боомтоор Хятад зүг зөөвөрлөдөг Монгол “Талын замаа” яаравчлан нэвтрүүлэхийг хүсч байна. “Лавлах сонин” http://www.guancha.cn/Neighbors/2015_07_10

Олон улсын мултимодаль тээвэр, эх газрын тээврийн _ Baidu номын сан, <http://wenku.baidu.com/>

Б.Хөгжилт: БНХАУ, Монгол Улсыг төмөр замаар холбох бодлого, үйл явцад хийсэн дүн шинжилгээ, “Олон улс судлал” 2014.№3